

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Чүлтэм	Дугаар	L115
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Цэнхэрмандал
Төрсөн газар	Цэнхэрмандал	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Согтуугийн хурал, Шаврын хурал, Далбангийн хурал	Сүм хийдийн дугаар	ХЭЦМ 001, ХЭЦМ 002, ХЭЦМ 003
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 12	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Согтуугийн хурал,  
Шаврын хурал, Далбангийн хурал

-Та нутаг орондоо байсан сүм хийдийн тухай сонссон дуулснаа ярьж өгнө үү ?

Манай нутагт хэд хэдэн хурал номын газар байжээ.

Согтуугийн хурал гэдэг нь Цэнхэрмандал сумд байсан өвөрмөц дэг жаягтай хурал байжээ. Зөвхөн зуны сард хурдаг. 4,4 -өөр нь эгнүүлсэн 8 гэр барьж айраг цагаагаа бэлтгэдэг байсан ба мөн хуралд оролцохоор ирсэн

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

мөргөлчид айраг цагаа, цагаан идээгээ бэлтгэж ирдэг байсан. Авгай хүүхнүүд нь дэргэр үсээ зүүгээд, авгай хувцсаа өмсөөд гэрүүд хэсээд айраг цагаа уугаад явдаг байсан. Лам нар нь ч их уудаг байсан. Ийм л хурал байсан.

Мөн энэ хуралд Жаргалтхаан сумаас Баатарын дацан болон бусад хийдүүдээс лам нар очиж хурдаг байсан. Шашны их сургуулийн захирал Ш.Сонинбаяр энэ хурлын тухай сонсоод сонин хурал байна гэж онцолж байжээ. Согтуугийн хуралд хурал дуусаад архи айраг уудаг байсан. Өргөл мөргөл хийж буй хүмүүс нь галуун хүзүүт алаг лонхоор архи аваачдаг. Лам нар сүсэгтнүүд бүгд уудаг байсан байх.

-Энэ хурлын газрын төвд нэр нь юу гэдэг байсан бэ?

Төвд нэрийг мэдэхгүй. Байгуулагдсан он тодорхойгүй. Би мэдэхгүй. Нутаг орны Шивэрийн хурал, Далбангийн хурал, Даянтын хийд, Бишрэлтийн отог зэргүүдтэй харилцаатай байсан. Дуганд хурдаг байсан. Их архи уудаг байсан гэж сонссон. Тийм учраас ингэж нэрлэгдсэн байх.

- Шаварын хуралын тухай?

Шаварын хурал гэж тухайн нутгийн хүмүүсийн санаачлагаар сайн дураар байгуулагдсан байх. Урианхад отогтой хамгийн ойр байсан. Цөөвтөр ламтай байсан гэж ярилцдаг.

Цэрэнжав гэдэг гавж Шаврын хурлын хүн байсан. Хожим 1980-аад оны үед нас барсан. Өргөл мөргөл хийхдээ ердийн үед Шаварын хуралд өгдөг байсан. Урд нь нугаар уул байсан. Нутгийн уул учраас Шаварын хурлын лам нар тахидаг байсан байх.

- Далбангийн хурал гэж ямархуу хурал номын газар байсан бэ?

Далбангийн хурал нь Урианхад отгийн хурал. Газар усаар нь Далбангийн хурал гэж нэрлэсэн. Урианхай улс амьдарч байсан. Тэгээд хийд байгуулсан. Далбангийн хурлыг нэлээд том хийд, олон ламтай байсан гэж сонссон.

- Даянтын хурал гэж бас нэг хурлын газар байжээ?

Дээр үед Сэцэн хаан хэсэг бүлэг хүмүүсийг нутаг заан гаргасан. Тэдэнд газар нутаг олдохгүй Даянтын эх Шургайт хоёрт л байсан. Тэд хамниган отог болж, Даянтын хурал гэж хийд байгуулсан. Бишрэлтийнхэн тэднийг их хавчиж байсан. Ардын засгийн дараа хоорондоо эвтэй болсон. Урьд нь тусгаарлагдмал хэсэг айл байсан. Цөөн хүмүүс байсан учраас бага хурал байсан байх. Өдөр тутам хурдаггүй байсан.

- Бишрэлтийн хуралын тухай?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бишрэлтийн хурал гэдэг нь Цэнхэрийн эхэнд байгаа болохоор Цэнхэрийн хурал гэх нь тохиромжтой. Нэлээд том хийд байсан. Ламын тоо олон. Жасын хөрөнгө мал ихтэй. Мал маллаж байсан хүмүүс байсан гэж сонсож байсан. Дамба гэдэг гэлэн Бишрэлтийн хуралд хурж байсан. Баригдаад 3,4 жил болоод эргэн ирээд 1980 –аад оны үед нас барсан.

-Баянзүрхийн хийдийн тухай?

Их том хийд байсан гэж сонссон. Сүүлд тэнд Баянзүрхийн хошуу байсан. Манай сүм Баянзүрхийн тамгаас эхэлсэн. Олон ламтай байсан. Хүрээ, Баязүрх гэдэг тахилгат уулыг тахидаг байсан. Одоо Жаргалтхаан сумаас ирж тахидаг. Цэндсүрэн гуай- Даянтын хурлаас бүгдийг нь мэднэ. Дэндэв гуай бас мэднэ.

-Бор өндөрийн хурлын талаар юу мэдэх вэ?

Бор өндөрийн хурал гэж сонссоноос өөр юм мэдэхгүй. Тэнүүн гэдэг газар Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутагт- Хэрлэнгийн зүүн хүрээ гэж байсан гэж сонссон. Ононгийн халуун рашаанд явахад хажуугаар нь гардаг. Их том хүрээ байсан гэж сонссон. Бэрээвэнгийн дайных ч байж мэднэ. Бэрээвэн зүүн зүгийн хамгийн том. Богд хийд байгуулах гэж шинжээчдийг газар үзүүлэхээр явуулсан. Нэг хонхор газарт жижиг бор гэртэй өвгөн эмгэн хоёр байсан. Өвгөнийг Балдан, эмгэнийг Цэвэлмаа гэдэг байсан. Тэр газрийг Балдан Бэрээвэн Даш Цэплин гэж нэрлэсэн. 3500 хүртэл тооны ламтай. Цам гардаг байсан. Манайхан Мандалт хайрханы тохойд Бэрээвний цаана очдог байсан. Жасын хөрөнгө их. Гол дуган 164 баганатай, хоёр давхар байсан.

-Шашин ном сэргэсний дараа танай сумд сүм дуган сэргээгдэв үү?

Шинээр сэргээсэн хийдэд сумаас 5 лам . анх нээгдэхэд Ж.Гомбо, Гочоо, Д.Намсрай, Дугарсүрэн, Гүржав, Лувсанцэрэн, Билгээ нар байсан. Дамба, Намсрай Багануурт бий. Сумын дарга Ишцэрэн, сумын захиргаа санаачлан зохион байгуулсан. 1990 онд нээгдсэн. 1991,92 онд хаагдсан. Ламгүй болсон. Хаагдталаа онцгой өдрүүдэд л хурдаг байсан.